



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/553

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын Сургалт, судалгаа арга зүйн хэлтсийн дарга Д.Нарандоржийн “Физикийн товч лавлах”, “Физикийн бодлого дасгалын хураамж” ном хэвлүүлэх зардалд 2000000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээний зардалд 2000000 төгрөг /Хоёр сая/-ийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.24 дахь “Чадварлаг-Ховдчууд” хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/553 дугаар захирамжийн хавсралт



“ФИЗИКИЙН ТОВЧ ЛАВЛАХ”, “ФИЗИКИЙН БОДЛОГО ДАСГАЛЫН ХУРААМЖ” НОМ ХЭВЛҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

дд	Материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	“Физикийн товч лавлах”, ном	250	4000	1000000
2	“Физикийн бодлого дасгалын хураамж” ном	250	4000	1000000
	Дүн	500		2000000

-оОо-